



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/108

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 4.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн авто зам дагуух үерийн усны шуудууны зураг төсөл боловсруулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүд: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)  
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)  
С.Ганхүлэг (Засаг даргын Тамгын газрын нярав)  
И.Маралмаа (Газрын даамал)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн сумын төвийн авто зам дагуух үерийн усны шуудууны зураг төслийг Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэж, архивт хүлээлгэн өгөхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН